	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.74
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Сумын Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөгөө зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, Засаг даргын бүрэн эрхийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, ИТХ, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, хууль тогтоомжийн биелэлтийг хангах, иргэдэд хуульд заасан үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж ажилласан байна.

Булган сум нь “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх төрийн бодлогыг сумынхаа онцлогт тохируулан боловсруулж, үр дүнтэй хэрэгжүүлэх өндөр чадвартай, зөв зохион байгуулалттай, хариуцлагатай удирдлагын тогтолцоог бүрдүүлж, ард иргэдийнхээ амьдрах орчин сайжруулах, аж амьдралыг дээшлүүлэх” эрхэм зорилгыг дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилтын хүрээнд: Ажлын хариуцлагыг дээшлүүлж, иргэдэд хүнд сурталгүй цаг хугацаанд үйлчилгээ үзүүлэх, орон нутгийн бизнесийн таатай орчныг бүрдүүлж, эдийн засгийн өсөлтийг хангаж улмаар сумын төсөв санхүүгийн хариуцлага, хяналтыг сайжруулж, ил тод үр ашигтай байдлыг эрхэмлэн, орон нутгийн хөгжлийг дэмжсэнээр сумын эдийн засгийн өсөлтийг иргэн бүрт хүргэж, ядуурлыг бууруулах зорилготой ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Булган сумын Засаг дарга нь Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь аймгийн Төсвийн ерөнхийлөгчийн харьяа орон нутгийн төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм.

Булган сумын төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2022 онд шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан “Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,797.1 сая төгрөгөөр буюу 74.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	215,941.02	181,307.54	-34,633.48
Авлага	221,498.60	268,495.77	46,997.17
Бараа материал	369,112.60	103,099.39	-266,013.21
Үндсэн хөрөнгө	8,365,215.20	1,821,778.07	-6,543,437.13
Нийт хөрөнгө	<u>9,171,767.44</u>	<u>2,374,680.77</u>	<u>-6,797,086.67</u>
Өр төлбөр	64,661.70	8,686.40	-55,975.30
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	9,107,105.73	2,365,994.37	-1,535,613.19
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<u>9,171,767.44</u>	<u>2,374,680.77</u>	<u>-6,797,086.67</u>

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Хүснэгтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансуудад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 181.3 сая төгрөг болж, өмнөх оноос 34.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+),
			Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	-	-	
Банканд байгаа бэлэн мөнгө	215,941.02	181,307.54	-34,633.48
Төгрөг	215,941.02	181,307.54	-34,633.48

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төрийн сангийн харилцах	192,578.09	174,097.54	18,480.55
Арилжааны банк дахь харилцах	23,362.19	5,209.99	18,152.20
Нэмэлт санхүүжилтийн харилцах	0.73	2000.0	19,99.27
Дүн	215,941.02	181,307.54	-34,633.48

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Мөнгөн хөрөнгө данс оны эхнээс 34.6 сая төгрөгөөр буурсан нь Сум хөгжүүлэх сангийн мөнгөн хөрөнгө буурсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт

Мөнгөн хөрөнгөтэй холбоотой алдаа зөрчил илрээгүй.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 268.5 сая төгрөг болж, өмнөх оноос 46.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	4,129.56	1,952.54	-2,177.02
Байгууллагаас авах авлага	661.73	19,550.99	18,889.26
Хувь хүмүүсээс авах авлага	0.00	1000.0	1000.0
Хувь хүмүүст олгосон зээл	216,707.30	246,992.22	30,284.92
Дүн	221,498.60	268,495.77	46,997.17

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Орон нутгийн хөгжлийн сангийн болон Сум хөгжүүлэх сангийн авлага нэмэгдсэнтэй холбоотой авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 46.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Аудитын илрүүлэлт

Авлагатай холбоотой алдаа зөрчил илрээгүй.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 103.1 сая төгрөг болж, өмнөх оноос 266.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	15,131.58	27,990.87	12,859.29
Тусгай зориулалттай материал	736.20	236.20	-500.0
Эм боох материал	14,395.38	27,754.67	13,359.29
Бэлэн бүтээгдэхүүн	233.65	233.65	0.00
Хангамжийн материал	362,921.86	74,874.86	-288,047.00
Бичиг хэргийн материал	4,864.89	2,088.90	-2,775.99
Аж ахуйн материал	149,172.17	12,468.75	-136,703.42
Сэлбэг хэрэгсэл	1,020.03	415.00	-605.03
Түлш, шатах тослох материал	49,936.05	9,485.10	-40,450.95
Хүнсний материал	86,387.34	0.00	-86,387.34
Бусад хангамжийн материал	61,541.36	50,417.10	-11,242.60

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Мал амьтад	825.50		-825.50
Дүн	369,112.60	103,099.39	-266,013.21

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Бараа материалын үлдэгдэл буурсан нь боловсрол, эрүүл мэндийн салбарын байгууллагуудын бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн бараа материалтай холбоотой байна.

Аудитын илрүүл

Бараа материалтай холбоотой алдаа, зөрчил илрээгүй.

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө байхгүй байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 3,472.2 сая төгрөг болж, өмнөх оноос 7,298.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	10,611,171.56	3,454,710.01	-7,156,461.55
Барилга, байгууламж, орон сууц	7,217,667.40	814,302.37	-6,403,365.03
Авто-тээврийн хэрэгсэл	330,351.19	147,540.89	-182,810.29
Машин тоног төхөөрөмж(компьютер)	836,617.91	384,326.33	-452,291.58
Тавилга, аж ахуйн эд хогшил	252,962.39	34,353.99	-218,608.40
Зам, гүүрийн байгууламж	1,648,457.57	1,726,457.57	78,000.00
Бусад үндсэн хөрөнгө	284,185.46	347,728.84	63,543.39
Ном	40,929.64	0.00	-40,929.64
Биет бус хөрөнгө	160,036.40	17,536.26	-142,500.14
Програм хангамж	4,408.40	1,883.40	-2,525.00
Бусад биет бус хөрөнгө	159,036.48	16,666.48	-142,370.00
	10,771,207.96	3,472,246.27	-7,298,961.69

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл буурсан нь боловсрол, эрүүл мэндийн салбарын байгууллагуудын бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн үндсэн хөрөнгөтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Үндсэн хөрөнгөтэй холбоотой алдаа, зөрчил илрээгүй.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 8.6 сая төгрөг болж, өмнөх оноос 55.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	38,054.53	8,686.40	-29,368.13

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Байгууллагад төлөх өглөг	339.38	0.00	-339.38
Хувь хүмүүст төлөх өглөг	26,267.79	0.00	-26,267.79
Дүн	64,661.71	8,686.40	-55,975.30

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Өр төлбөр данс 55.9 сая төгрөгөөр буурсан нь ерөнхий боловсролын сургууль, эрүүл мэндийн төвийн өр төлбөр буурсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Өр төлбөртэй холбоотой алдаа, зөрчил илрээгүй.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 2,365.9 сая төгрөг болж, өмнөх оноос 6,741.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
			Өсөлт (+),)	Бууралт (-)
Засгийн газрын хувь оролцоо	9,107,105.74	2,365,994.37		-6,741,111.36
Засгийн газрын оруулсан капитал	2,386,379.96	850,766.78		-1,535,613.19
Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	2,386,379.96	850,766.78		-1,535,613.19
Хуримтлагдсан үр дүн	2,845,043.28	638,927.51		-2,206,115.77
Өмнөх үеийн үр дүн	3,111,022.36	7,388,586.06		4,277,563.70
Тайлант үеийн үр дүн	-265,979.08	-6,749,658.55		-6,483,679.47
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,875,682.49	876,300.09		-2,999,382.40

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлант онд -6,749.6 сая төгрөгийн үр дүнтэй ажилласан, боловсрол, эрүүл мэндийн салбарын байгууллагуудын бүтцийн өөрчлөлттэй холбоотой Засгийн газрын оруулсан капитал дансанд 1,535.6 сая, хөрөнгийн дахин үнэлгээний нөөц дансанд 2,999.4 сая төгрөгийн бууруулах бичилт, өмнөх үеийн үр дүн дансанд 4,277.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэх бичилт хийгдсэнтэй холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс 6,741.1 сая төгрөгөөр буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Булган сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 1,503.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,464.4 сая төгрөгийг урсгал зардалд, 39.4 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

БӨА-2023/07/НА-СТА-ТТЗ

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Нийт зардлын 989.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 405.4 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас, 108.8 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Булган сум нь 2022 онд гүйцэтгэлээр нийтдээ 1,399.0 сая төгрөгийн санхүүжилтийн орлого бүрдүүлснээс орон нутгийн төсвөөс 986.6 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангаас 366.0 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 46.5 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Хоршоог хөгжүүлэх сангийн үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөлт 108.0 сая төгрөг ба 62.3 сая төгрөгөөр тасарсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,481.9 сая төгрөг буюу 98.5 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь төвлөрүүлсэн болон дутуу авсан санхүүжилт, тасарсан орлоготой холбоотой байна.

Сумын орон нутгийн төсвийн орлогын талаар:

Аймгийн ИТХ-ын 2021 оны “Орон нутгийн төсөв батлах тухай” IV дүгээр хуралдааны 53 дугаар тогтоолоор Булган сумын 2022 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 504.0 сая төгрөгөөр баталж, Аймгийн ИТХ-ын хуралдааны “2022 оны төсөвт тодотгол хийх тухай” 2022 оны 93 дугаар хуралдааны 04 дүгээр тогтоолоор 508.1 сая төгрөгөөр буюу 4.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Сумын ИТХ-ын 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн VIII дугаар хуралдааны 2022 оны төсөвт тодотгол хийх тухай 41 дүгээр тогтоолоор 2022 орлогын төлөвлөгөөг 508.1 сая төгрөгөөр хэвээр баталжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогод 636.9 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөөг 11.5 сая төгрөгөөр буюу 25.3 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №9	Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл			/мянган төгрөг/
Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
I.Татварын орлого	502,104.1	621,079.5	118,975.4	97.5%
II.Татварын бус орлого	6000.0	15,851.5	9,851.5	2.5%
Нийт дүн	508,104.1	636,931.0	128,826.9	100%

Эх сурвалж: Аудитын судалгаа

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд татварын орлогоос цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтээс орох орлого 85.3 сая, малд ногдуулах албан татвар 20.1 сая, улсын тэмдэгтийн хураамж 2.6 сая, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 0.6 сая, ан амьтны нөөц ашигласны нөөц ашигласны төлбөрийн орлого 94.4 сая төгрөгөөр, татварын бус орлогоос торгуулийн орлого 11.6 сая, бусад орлого 4.2 сая төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

Татварын орлогоос үйл ажиллагааны орлого 29.9 сая, хөрөнгийн орлого 28.4 сая, хөрөнгө борлуулсны орлого 0,3 сая, үл хөдлөх хөрөнгийн албан татвар 2.0 сая, бууны албан татвар 3.7 сая, хог хаягдлын үйлчилгээний хураамж 5.4 сая, газрын төлбөр 11.7 сая, ойн нөөц ашигласны төлбөр 1.9 сая төгрөгөөр, татварын бус орлогоос хүүгийн орлого 6.0 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Орон нутгийн ерөнхий орлогын 910 тоот дансанд оны эхэнд 67.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба Орон нутгийн орлогын 995 тоот дансаар 636.9 сая төгрөгийн татварын орлого оруулсан байна. Оны эцэст орон нутгийн төсвийн ерөнхий орлогын 910 тоот дансанд 131.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харъяа байгууллагууд 2022 онд 1,503.8 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж 98.5 хувь буюу 1,481.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан байна. Сумын Орон нутгийн хөгжлийн сангын төлөвлөгөө тасарсан байна. Төсөвт байгууллагууд батлагдсан төсөвтөө багтааж үйл ажиллагаа явуулж, хэмнэлтийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №10 Төсвийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэлтийн талаар:

/мянган төгрөг/

Д/д	Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
1	Сумын ИТХурал	72,397.9	72,397.9	0.00
2	Сумын ЗДТГазар	481,398.8	481,395.7	-1,003.1
3	СХСан	108,840.6	108,579.6	-261.0
4	ОНХСан	383,925.7	365,284.4	-18,641.3
5	ЕБ-ын 1 дүгээр сургууль	191,992.0	191,535.6	-456.4
6	Ёлт бага сургууль	80,952.3	79,852.4	-1,099.9
7	Шүвтэр бага сургууль	57,261.6	56,717.7	-543.9
8	Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг	52,479.7	52,168.5	-311.2
9	Хүүхдийн 2 дугаар цэцэрлэг	25,286.2	24,723.7	-562.5
10	Соёлын төв	20,951.2	20,950.7	-0,5
11	Эрүүл мэндийн төв	28,286.4	28,286.4	0.0
	Нийт дүн	1,503,772.4	1,481,892.9	-218,795.0

Эх сурвалж: Аудитын судалгаа

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 3.4 сая төгрөгийн, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 8.6 сая төгрөгийн нийт 12.0 сая нэмэлт санхүүжилт хүлээн авсан байна.

Үүнээс тээвэр шатахууны зардалд 4.0 сая, томилолтын зардалд 1.5 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 4.5 сая төгрөгийн нийтдээ 10.0 сая төгрөгийг зарцуулж, оны эцэст нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд 2.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Нэмэлт төсвийн гүйцэтгэл, орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайланг 2023 оны 3 дүгээр сарын 03 дугаар сарын 02-ны өдрийн 1/107 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 5,323.4 сая төгрөгөөс 1 хувиар буюу 53.2 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор сумын төсөв байгууллагууд бараа ажил, үйлчилгээний зардлуудыг хэмнэлттэй зарцуулсан байна. Тухайлбал: цалин хөлсний зардлыг 3.0 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 0.03 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 0.3 сая, урсгал шилжүүлгийг 14.5 сая төгрөгөөр буюу нийт 21.9 сая төгрөгөөр хэмнэж зарцуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад алдаа зөрчил гараагүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны мэдээллээс программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгахад төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 529.3 сая төгрөгийн 1 шийдвэр гарсныг шилэн дансанд мэдээлээгүй, мэдээлсэн байдлын хэрэгжилт 75 хувь байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад илэрсэн зөрчлийн дүнгээр албан шаардлага өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд Булган сумын ТТЗ-ийн төсвийн гүйцэтгэлийн 1, 2 дугаар улирлын мэдээ, хагас жилийн санхүүгийн тайланг байршуулаагүй, таван сая төгрөгөөс дээш татварын орлогын 186.7 сая төгрөгийн 7 орлогын гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш зарлагын 698.1 сая төгрөгийн гүйлгээг байршуулаагүй, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчилд албан шаардлага өгсөн ба тайлант онд биелэлтийг шалгахад хэрэгжээгүй байна.

Төрийн албаны зөвлөлийн 2019.07.16-ны өдрийн 42 дугаар тогтоолын 2-р хавсралтаар баталсан сумын Санхүүгийн албаны ажлын байрны тодорхойлолтод заасны дагуу Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн 2 дугаар гарын үсгийг санхүүгийн албаны даргаар зуруулж, тайлан, баланс гаргуулах, зөрчлийг арилгаж ажиллах талаар 1 заалттай зөвлөмж өгөгдсөний биелэлтийг хангаж ажилласан байна.

Хүснэгт №11 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					-
Албан шаардлага	1	884,800.0	0	0	0%
Зөвлөмж	1	0	1	0	100%
Нийт дүн	1	884,800.0	1	0	50%

Эх сурвалж: Аудитын судалгаа

Тус сумын Санхүүгийн албаны дарга нар шинээр томилогдсонтой холбоотой сахилгын хариуцлага ногдуулах боломжгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар 2021, 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар давтан гарсан зөрчлүүдийг арилгасан эсэхийг анхаарах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Булган сумын Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 529.3 сая төгрөгийн зөрчил илэрч албан шаардлага өгөв.

5.1 Төлбөрийн акт

Акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Аудитын дүнгээр дараах зөрчилд албан шаардлага өгөв.Үүнд:

1. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны мэдээллээс программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгахад төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 529.3 сая төгрөгийн 1 шийдвэр гарсныг шилэн дансанд мэдээлээгүй, мэдээлсэн байдлын хэрэгжилт 75 хувь байна.

5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 5 тусгай сангийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 1 байгууллага, 5 сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн нэгтгэлд Ерөнхий боловсролын 1, 2,3 дугаар сургууль, Хүүхдийн 1,2 дугаар цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төв зэрэг байгууллагуудад орон нутгийн төсвөөс олгосон тогтмол зардлын санхүүжилтийг хамруулсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн. Сумын ИТХ, Төрийн сан, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сан, Эргэлтийн эмийн сан, Байгаль хамгаалах сангуудын санхүүгийн тайланг түүвэрт хамруулж үзсэн.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоогдсон байна.

Хүснэгт №12 : Төсөвт байгууллагуудын алдаа зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах санал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сумын ИТХурал	0	0										
2	Сумын ЗДТГазар	3	114873					2	114,872.60	1			
	Дүн	3	114873	0	-	0	0	2	114872.6	1	-	0	0

Эх сурвалж: Аудитын судалгаа

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Дүн													

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс											
		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн													

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 529.3 сая төгрөгийн 1 шийдвэр гарсныг шилэн дансанд мэдээлээгүй, мэдээлсэн байдлын хэрэгжилт 75 хувь байна.	1	529,327.2			1	529,327.2		
Дүн	1	529,327.2			1	529,327.2		
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	529,327.2			1	529,327.2		